




Увс аймаг дахь Шүүхийн
тамгын газар

Шүүхийн мэдээлэл /Эмхэтгэл/

2026 он

УВС АЙМАГ ДАХЬ АНХАН ШАТНЫ ШҮҮХҮҮД
УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР



Эмхэтгэсэн:
Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн
Ерөнхий шүүгч Д.Алтанцэцэг
Шүүгчийн туслах Б.Байгальмаа
Техник редактор: Мэдээлэл технологийн мэргэжилтэн
Д.Цэвээндорж

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар, Улаангом сумын гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх салбар зөвлөл хамтран эрхлэн хэвлүүлэв.

Эмхэтгэлийн тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод явуулна гэж заасан.

Шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газраас шүүхийн нээлттэй байдлыг хангах чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс тухайлбал,

-Төрийн нууцад хамаарах хэрэг болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд хаалттай явуулахаар тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаан нээлттэйгээр явагдаж байна. Иймд шүүхийн аль ч шатны нээлттэй шүүх хуралдаанд хүссэн иргэн сууж, ажиглаж болно.

-Шүүхийн цахим сайтууд ажиллаж байгааг бөгөөд Увс аймаг дахь шүүхүүдийн хувьд www.court.uv.gov.mn цахим хуудас болон Увс аймаг дахь шүүхийн тамгын газар нэртэй Facebook хаягаар шүүх хуралдааны тов, тойм болон холбогдох бусад мэдээ мэдээллийг хүргэж байна.

-Нийт шүүхүүдийн шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан www.shuuk.mn ажиллаж байна.

- Авлигын гэмт хэргийн анхан ба давж заалдах шатны нээлттэй шүүх хуралдааныг Facebook хуудсаар шууд дамжуулан хүргэж ажиллаж байна.

-Сургалт, үйл ажиллагаа танилцуулах өдөрлөг зохион байгуулах зэрэг болно.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар болон Увс аймгийн Улаангом сумын гэмт хэргээс урьдчлан сэргийлэх зөвлөлөөс хамтран бэлтгэсэн энэхүү эмхтгэлээр Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн эрүү, иргэн, зөрчлийн хэрэг шийдвэрлэлт, Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн болон Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны мэдээллийг 2025 оны жилийн эцсийн байдлаар танилцуулахын зэрэгцээ шүүхэд ямар төрлийн хэрэг маргаанууд зохилон шийдвэрлэгдэж байгаа, мөн зонхилон шийдвэрлэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр хэрэгжиж эхэлсэн иргэний хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл зэргийг хүргэхийг зорилоо.

Энэхүү эмхтгэл нь шүүхийн нээлттэй байдлыг хангах, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тодорхой нөлөөллийг үзүүлнэ гэдэгт итгэж байна.

УВС АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.БАТТУЛГА



УВС АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ

Увс аймаг дахь Захиргааны хэргийн шүүх нь 2004 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд захиргааны хэргийн шүүх нь хүн, хуулийн этгээдийн захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг хянан шийдвэрлэдэг.

Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг нэхэмжлэл, гомдлын хүрээнд хянах хэрэг маргааны төрлөөр дагнасан шүүх юм.

“нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг хэлнэ.

/Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.3/

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд Захиргааны ерөнхий хуулийг баталсан нь 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Уг хууль нь Монгол Улсад анх удаа захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн зохицуулснаараа эрх зүйн хөгжилд болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, иргэдийн оролцоог хангадаг болоход чухал түлхэц болсон юм.

Захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан

1

Газар өмчлөх, ашиглах эрхийн маргаан



2

Тендер, сонгон шалгаруулалтын маргаан



3

Сонгуулийн маргаан



4

Улсын бүртгэлийн маргаан

5

Татварын маргаан



6

Төрийн албаны маргаан

7

Хяналт шалгалтын маргаан



8

Ашигт малтмалын маргаан

9

Тусгай зөвшөөрлийн маргаан



10

Нийгмийн даатгалын маргаан

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА



НЭХЭМЖЛЭГЧ

Захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй хүн хуулийн этгээд



НЭХЭМЖЛЭЛИЙГ ХАРИУЦАГЧИД ГАРДУУЛАХ

Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд долоо, орон нутагт 14 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна



ХАРИУЦАГЧ ХАРИУ ТАЙЛБАР ИРҮҮЛЭХ

Хэргийн оролцогчид шүүхэд гаргасан нэхэмжлэл, хариу тайлбарын үндэслэлийн талаарх нотлох баримтыг гаргаж өгнө



УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нотлох баримт гаргуулах, нотлох баримт хасуулах, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх



ШҮҮХ ХУРАЛДААН ТОВЛОХ, ХЭРГИЙГ ШҮҮХ ХУРАЛДААНААР ХЯНАН ХЭЛЭЛЦЭХ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ НЭХЭМЖЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Нэхэмжлэл нь ЗХШХШТХ-ын 52 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх



ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ҮҮСГЭХ

ЗХШХШТХ-ын 54 дугаар зүйлд заасан үндэслэл байхгүй бол 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэнэ.



ШҮҮХ НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ

Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг гүйцэтгэнэ



ТАЛУУД ХЭРГИЙН МАТЕРИАЛТАЙ ТАНИЛЦАХ

Талууд хэргийн материалтай танилцах, тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцох эрх, үүрэгтэй;




ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЧГЭЭР ГАРАХ

Шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргана.

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны тоон үзүүлэлт

2025 онд Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх нийт 55 маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс 14 нэхэмжлэлийг хангаж, 3 нэхэмжлэлийг зарим хэсгийг хангаж, 14 нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 2 нэхэмжлэлийг дахин шинэ захиргааны акт гаргах хүртэл хугацаанд түдгэлзүүлж, 17 нэхэмжлэлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байна.

Хянан шийдвэрлэсэн хэргийг маргааны төрлөөр авч үзвэл:



Захиргааны байгууллага нийтийн эрх зүйн хүрээнд холбогдох шийдвэрийг гаргахдаа Захиргааны ерөнхий хуульд заасан журмыг баримталдаг бөгөөд захиргааны байгууллагын хууль бус шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шүүх хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан.

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулиар аймагт сум дундын шүүх ажиллагааг заасан тул өмнө нь дагнасан шүүхийн хэлбэрээр шүүн таслах ажиллагааг эрхэлж байсан Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нэгтгэгдэж 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн иргэний хэргийн шийдвэрлэлтийн мэдээ /2025 он/:

Нийт 1351 хэрэг хянан шийдвэрлэснээс


Иргэний хуулиар:



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар:



Салбарын хуулиар:



Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал

Эвлэрүүлэн зуучлалын зорилго нь талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олоход нь зуучлагч дэмжлэг үзүүлж, тэдгээрийн хоорондын харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар, шуурхай, зардал багатай зохицуулахад оршино:

Увс аймаг дахь сум дундын шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар нийт 249 өргөдөл хүлээн авснаас 81 өргөдлийг амжилттай хянан шийдвэрлэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинээр хэрэгжиж буй тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай



1

Монгол Улсын Их Хурлаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэг “Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа”-г шинээр нэмж, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан ба 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн.

2

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, богино хугацаанд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх боломжтой юм.

3

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ДОЛДУГААР¹ БҮЛЭГТ Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг ямар төрлийн хэргүүдэд хэрэгжүүлэх хэдий хугацаанд хэргийг хянан шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгаж өгсөн.

Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:



Бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;



Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;



Хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;



Бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах



Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.



Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинээр хэрэгжиж буй тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай



Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол



ИХШХШТХ-ын 75^{1.1.1}-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;



Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус нэг удаагийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75^{9.3}-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн мэдээ /2025 он/:

Нийт 275 хэрэг хянан шийдвэрлэснээс:




Хүнийг алах




Хүнийг амиа хорлох
нөхцөл байдалд хүргэх



Хүний эрүүл мэндэд хүнд
хохирол санаатай
учруулах



Хүний эрүүл мэндэд
хүндэвтэр хохирол санаатай
учруулах



Бусдын эрүүл
мэндэд хөнгөн
хохирол учруулах




Гэр бүлийн
хүчирхийлэл



Хүчиндэх



16 насанд хүрээгүй
хүнтэй бэлгийн
харьцаанд орох




Хүүхэдтэй хэрцгий
харьцах




Хулгайлах



Залилах




Хөрөнгө завших




Бусдын эд хөрөнгийг
авахаар заналхийлэх



Автотээврийн
хэрэгслийг
зөвшөөрөлгүйгээр
авч явах



Эд хөрөнгө устгах,
гэмтээх




Болгоомжгүйгээр эд
хөрөнгө устгах, гэмтээх

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн мэдээ /2025 он/:


Нийт 275 хэрэг хянан шийдвэрлэсэнээс:



Мал хулгайлах




Худал мэдүүлэх



Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших




Хахууль авах



Хахууль өгөх




Хууль сахиулагчийг эсэхгүүцэх



Хууль бусаар ан агнах




Хууль бусаар мод бэлтгэх



Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах



Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах



Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих



Мөрийтэй тоглоом зохион байгуулах

Хорих ялаар 71 хүн, торгох ялаар 143 хүн, нийтэд тустай ажил хийлгэх ялаар 43 хүн, зорчих эрхийг хязгаарлах ялаар 39 хүн тус тус шийтгүүлсэн байна.

Мөн түүнчлэн албадлагын арга хэмжээ 10 хүнд, 17 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, 2 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн байна.

Түгээмэл үйлдэгдэж байгаа гэмт хэрэг



Нийт шийдвэрлэгдсэн хэргийн 50 хувийг бусдын эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг эзэлж байна.

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хувьд ихэнхдээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас гэмт хэрэгт холбогдон ял шийтгэл хүлээж байна.

Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл Жолооч:

-Согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

-Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

-Согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол:



тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 7 -30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол:

тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг 1-3 жил хүртэл хугацаагаар хасаж 2700-14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,



эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх,



эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах



эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промиль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промиль (%) илэрснийг ойлгоно.

Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах

Бусдын эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн хувьд согтуугаар үл ялиг зүйлээр шалтаглан бусдыг зодож хөнгөн хохирол учруулах нь түгээмэл байна.

Эрүүгийн хуулийн 11.6. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол:

- 450-1350 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

-эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх

-эсхүл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.



Хүний эрүүл мэндэд хохирлын хөнгөн зэргийг тогтоохдоо дараах байдлыг тогтооно:

1.гэмтэл, түүнээс үүссэн эд эрхтний бүтэц, үйл ажиллагааны хямрал нь эрүүл мэндийг дөрвөн долоо хоногоос доош буюу түр хугацаагаар сарниулсан;

2.ерөнхий хөдөлмөрийн чадвар бага хэмжээгээр буюу 5-10%-аар тогтонги алдагдсан.

Энэ гэмт хэргийг

-онц харгис хэрцгийгээр

-олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар;

-захиалгаар;

-өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор;

-өөртөө, бусдад эдийн, эдийн бус ашигтай байдал бий болгох зорилгоор;

-хоёр, түүнээс олон хүнийг;

-хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, жирэмсэн болохыг мэдсээр байж; гэр

бүлийн хүчирхийлэл үйлдэж;

-эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг;

-зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааныхаа явцад; -

-бүлэглэж;

-эрүүдэн шүүж;

-цус, эд, эрхтнийг авах зорилгоор;

-үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж үйлдсэн бол

450-2700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх,

эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэж гэр бүлийн хамгаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцаж, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэх мэт үйлдлийг ойлгоно.

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

-зодсон;

-хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;

-бусадтай харилцахыг хязгаарласан;

-хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь

эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.



Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:

-зодсон;

-харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;

-тэтгэвэр, тэтгэмж, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол

- зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,

эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Хүндрүүлэх бүрэлдэхүүн

Энэ гэмт хэргийг:

-хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

-асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;

-таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол

-6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,

-эсхүл 6 сараас 2 жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.





Зөрчлийг хэрэг


Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1-т “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ”.

2-т “Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно”


Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх нь 2025 онд нийт 962 зөрчил хянан шийдвэрлэснээс 769 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.2, 5.3-т заасан согтуурсан мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон гэх зөрчлийн дагуу шийтгэл оногдуулсан байна Энэ нь шийтгэл оногдуулсан нийт зөрчлийн хэргийн 77.8 хувийг эзэлж байна.

Мөн 152 иргэнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилөөр, 24 иргэнд танхайрах зөрчлөөр шийтгэл оногдуулсан байна.

Зөрчлийн төрлөөр нь авч үзвэл:



Баривчлагдсан иргэдийг хүйсээр нь авч үзвэл:



Хайртай хүмүүсийнхээ төлөө эрүүл жолоо бариарай.
Нэг хундага=Нэг осолын эхлэл



Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

Монгол улсын шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд давж заалдах шатны шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж зохицуулжээ. Үүнд:

- 1.хуульд заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх;
- 2.Хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;
- 3.Хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар доод шатны шүүх хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;
- 4.Шүүн таслах ажиллагааны практикийг судалж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа Улсын дээд шүүхэд уламжлах

Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2025 оны байдлаар нийт эрүүгийн 63, иргэний 36, зөрчлийн-90 хэрэг хянан шийдвэрлэсэн. Үүнээс:


Эрүүгийн 63 хэргээс:



Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.



Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон




Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан

Иргэний 36 хэргээс:



Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.



Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон



Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан

Зөрчлийн 90 хэргээс:



Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.



Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.



Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон



Албадлагын арга хэмжээг хөнгөрүүлж эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан

УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД
ХҮСЭЛТ ГАРГАХ НЬ:

2025.11.30

Улаангом сум

Хүсэлт гаргасан: Овог, эцгийн нэр, өөрийн нэр

Хаяг: Оршин суугаа хаяг, утасны дугаар

Хүсэлт: Ажиллаж байсан байдлаа тогтоолгох тухай

Хүсэлтийн агуулга: Миний бие ньонд төрсөн.....ондсургуулийг төгсөөд
.....мэргэжил эзэмшсэн.

Би 1989-1993 он дуустал хугацаанд Увс аймгийн Өлгий сумын сургуульд бага ангийн багшаар ажилласан. 1994 оноос хойш хэсэг хугацаанд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаад 2000 оноос хойш Улаангом сумын 1-р сургуульд багшаар ажиллаж байна. Одоо өндөр насны тэтгэвэрт гарах болж бичиг баримтаа нийгмийн даатгалын байгууллагад шалгуулахад Өлгий суманд ажиллаж байсан талаарх баримт болох ажилд орсон болон ажлаас чөлөөлөгдсөн тушаал байхгүй байна.

Аймгийн архиваас ажилд орсон болон гарсан тушаалыг шүүлгүүлэхэд тушаал маань олдоогүй тул шүүхэд хандаж ажиллаж байсан байдлаа тогтоолгох шаардлагатай болсон.

Иймд миний 1989 оны 9 сарын 01-ний өдрөөс 1993 он дуустал хугацаанд Увс аймгийн Өлгий сумын сургуульд бага ангийн багшаар ажиллаж байсан болохыг тогтоож өгнө үү.

Хүсэлтэд хавсаргасан баримт:

- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /70,200 төгрөг/
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Хөдөлмөрийн дэвтрийн нотариатаар батлуулсан хуулбар
- Аймгийн архивын газраас гаргасан цалингийн баримт
- Өлгий сумын сургуулийн захирлын ажил хариуцуулах тухай тушаалын хуулбар
- Хамт ажиллаж байсан талаар гэрчийн мэдүүлэг өгөх иргэний бичиг баримт

Хүсэлт гаргасан:

А.Б

Зээлийн гэрээний маргааны нэхэмжлэлийн загвар

..... шүүхэд

нэхэмжлэл гаргах нь:

.... оны-р сарын-ны өдөр

Нэхэмжлэгч: овогт

.....аймаг,сум, хороо, байр,тоо

Утас:.....

Хариуцагч:

.....аймаг,сум, хороо, байр,тоот

Утас:.....

Нэхэмжлэлийн шаардлага:Зээлийн гэрээний үүрэгт.....төгрөг гаргуулах тухай.

..... би-тэй оны ... дугаар сарын
....-ны өдөр “Зээлийн гэрээ” байгуулан төгрөгийг ...хувийн хүүтэй,..... сарын
хугацаатайгаар оны ...-р сарын-ны өдөр хүртэл зээлүүлсэн. Зээлийн гэрээнд
..... нотариатаар батлуулсан. Гэрээний хугацаа дууссан боловч
зээлдэгч нь зээлийн төлбөрөө төлөөгүй өнөөг хүрч байна. Зээлийн
гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутам хувийн алданги тооцож ...
хоногийн алданги, үндсэн зээлийн төгрөг, түүний хүү болох
төгрөгийн хамт нийт төгрөгийг хариуцагч-ээс
гаргуулан өгнө үү.

Нэхэмжлэлд: /Хавсаргасан баримтын жагсаалтаа бичнэ үү. Мөн хуудсаа дугаарлана уу/

1. Нэхэмжлэлхувь

2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт-1 хуудас

3. “Зээлийн гэрээ”-ний ... хувь

4. Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар -хувь

/Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг
гаргаж өгнө/

Нэхэмжлэгч:...../ /

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД
НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

20__оны __сарын __өдөр

Улаанбаатар хот

Нэхэмжлэгчийн нэр:

Нэхэмжлэгчийн оршин суугаа газрын хаяг:

Нэхэмжлэгчийн утас:

Нэхэмжлэгчийн цахим шуудангийн хаяг:

Хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтан:

Хариуцагчийн оршин суугаа газрын хаяг:

Хариуцагчийн утас:

Анхаарах зүйл: Энэ хэсэгт тухайн маргах гэж буй захиргааны /акт/ шийдвэрийг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтныг хариуцагчаар тодорхойлж бичсэн байх шаардлагатай.

Жишээ нь: Нийслэлийн Засаг даргын гаргасан захиргааны актыг хүчингүй болгуулах агуулгаар маргаж байгаа тохиолдолд Нийслэлийн Засаг дарга хариуцагч байна. Түүнээс бус түүний харьяа байгууллага болох Нийслэлийн газрын алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг хариуцагчаар тодорхойлох боломжгүй.

Нэхэмжлэлийн шаардлага:

Анхаарах зүйл: Энэ хэсэгт ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3-т заасан нэхэмжлэлийн шаардлагын төрлүүдээс судлан, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн тогтоох боломжтой хамгийн оновчтой нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлох ёстой.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хандсан эсэх:

Анхаарах зүйл: Энэ хэсэгт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар маргаж буй захиргааны актыг гаргасан байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллагад хандсан эсхүл хандах шаардлагагүй талаараа заавал бичнэ.

Жишээ нь:

1. Баянгол дүүргийн Засаг даргын захирамжтай холбоотойгоор маргаж байгаа бол Нийслэлийн Засаг даргад хандсан байх,

2. Нийслэлийн Засаг даргын захирамжтай маргаж байгаа бол шууд шүүхэд хандан нэхэмжлэлээ гаргах боломжтой. Учир нь дээд шатны захиргааны байгууллага байхгүй.

Нэхэмжлэл гаргах хуульд заасан хугацаандаа эсэх:

Анхаарах зүйл: Энэ хэсэгт Захиргааны актыг хэзээ мэдсэн, хэзээ хүлээн авсан, түүнээс хойш 30 хоногтоо багтаан нэхэмжлэлээ гаргаж байгаа буюу хуульд заасан нэхэмжлэл гаргах хугацаанд багтаан гаргаж байгаа тухайгаа бичнэ. /ЗХШХШТХ-ийн 14-р зүйлд заасан хугацаанд байх/

Нэхэмжлэлийн үндэслэл:

Анхаарах зүйл: Энэ хэсэгт Тодорхойлсон нэхэмжлэлийн шаардлагатайгаа уялдуулан дараах үндэслэлүүдийн аль тохирохыг сонгон маргааны үйл явдалтайгаа холбон дэлгэрэнгүй байдлаар хууль зүйн үндэслэлтэйгээр нэхэмжлэлийн үндэслэл хэсэгтээ тайлбарлан бичнэ.

- **Захиргааны акт, гэрээг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох, эсхүл эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, захиргааны акт гаргахыг даалгах нэхэмжлэлийн хувьд:** нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн талаар,
- **Хохирол гаргуулах нэхэмжлэлийн хувьд:** захиргааны байгууллага ямар үүргээ биелүүлээгүйгээс, эсхүл захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэхийг хүсэж байгаа талаар,
- **Нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд:** эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэх талаар,
- **Захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэлийн хувьд:** ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн талаар,
- **Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд:** хүн, хуулийн этгээдийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй болон ямар хуультай зөрчилдсөн талаар,

Хавсаргасан материал:

Анхаарах зүйл: Энэ хэсэгт зайлшгүй хавсаргаж өгөх ёстой өөрт байгаа дараах баримтуудыг нотлох баримтын шаардлага хангасан байдлаар жагсаалт гарган өгөх, үнэхээр боломжгүй тохиолдолд нотлох баримтын шаардлага хангасан байдлаар гаргуулах боломжтой эх сурвалжаа заан ирүүлэх шаардлагатай.

- Нэхэмжлэл 2 хувь/хариуцагчийн тоогоор/

- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

- Иргэний үнэмлэхийн хуулбар

/Компани нэхэмжлэл гаргаж байгаа бол компанийн дүрэм, гэрчилгээ/

- Нэхэмжлэлийн үндэслэлээ нотолж буй баримтууд

Нэхэмжлэл гаргасан:


Энэ хэсэгт:

- Иргэн хүний хувьд нэрээ бичиж, гарын үсэг зурж баталгаажуулсан байх,
- Компанийн хувьд албан бланк дээр хэвлэж, эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байх шаардлагатай


МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ



Анхан болон давж заалдах
шатны шүүх, шүүхийн Тамгын
газрын цахим хуудас



Анхан болон давж заалдах
шатны шүүх, шүүхийн Тамгын
газрын фэйсбүүк фэйж
хуудас



Шүүхийн шийдвэрийн
цахим сан



Анхан болон давж заалдах
шатны шүүхийн шүүх
хуралдааны тов, тойм

Холбоо барих:

Хаяг: Шүүхийн тамгын байр, Рашаантын гудамж 109, Улаангом сум, Увс аймаг

УТАС: 70454570

WWW.FACEBOOK.COM/UVSCOURTS

WWW.COURT.UV.GOV.MN